

Есдүгээр зүйл

1. Харьяатыг сонгон авах тухай эцэг эх нь өргөдөл гаргаагүй **ХУУХЭД:**

а) хэрэв Хэлэлцэн Тохирогч хоёр ЭТГЭЭДИЙН аль нэгний нутаг дэвсгэрт төрсөн бол эл ЭТГЭЭДИЙН харьяатыг хадгална.

б) хэрэв гуравдахь улсын нутаг дэвсгэрт төрсөн бол эл улсад ирэхээс өмнө эцэг эх нь байнга оршин сууж байсан Хэлэлцэн Тохирогч тэр ЭТГЭЭДИЙН харьяатыг хадгална.

Хэрэв эцэг эх нь Хэлэлцэн Тохирогч хоёр ЭТГЭЭДИЙН аль алиных нь нутаг дэвсгэрт оршин сууж байгаагүй бол эхийнхээ харьяат байгаа Хэлэлцэн Тохирогч тэр ЭТГЭЭДИЙН харьяатыг хадгална. Хэрэв эх нь эх байх эрхээ хасуулсан бол хуухэд эцгийнхээ харьяат байгаа Хэлэлцэн Тохирогч тэр ЭТГЭЭДИЙН харьяатыг хадгална.

в) хэрэв эцэг эх нь гэр бул болоогүй бол хуухэд нь эцэг эх байх эрхтэй эцэг буюу эхийнхээ харьяат байгаа Хэлэлцэн Тохирогч тэр ЭТГЭЭДИЙН харьяатыг хадгална.

2. Хэрэв эцэг эхийн аль нэг нь долдугаар зүйлийн 2-т заасан хугацаа дуусахаас өмнө нас барсан буюу хаана байгаа нь мэдэгдэхгүй, эсгүл хуухэд хумуужуулэх эрхээ хасуулсан бол аль байгаа эцэг буюу эхийнхээ харьяат байгаа Хэлэлцэн Тохирогч тэр ЭТГЭЭДИЙН харьяатыг хадгална.

3. Эцэг эх нь нас барсан буюу хаана байгаа нь мэдэгдэхгүй, эсгүл эцэг эх байх эрхээ хасуулсан бол долдугаар зүйлийн 2-т дурдсан хугацаа дууссан өдрөөс эхлэн, уг хуухэд нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн Тохирогч тэр ЭТГЭЭДИЙН харьяатыг хадгална.

III БҮЛЭГ

ЕРӨНХИЙ ЗААЛТ

Аравдугаар зүйл

1. Энэхуу Гэрээний дагуу харьяатаа сонгон авах тухай өргөдлөө гаргасан хумуус, эсгүл харьяатыг нь сонгон авахаар эцэг эхээс нь өргөдөл ирэн хуухдууд уг өргөдлийг өгсөн өдрөөс эхлэн, харьяатыг нь сонгон авсан Хэлэлцэн Тохирогч ЭТГЭЭДИЙН харьяатыг хадгална.

2. Харьяатаа сонгон авах тухай өргөдөл гаргаагүй хумуус эсгүл харьяатыг нь сонгон авахаар эцэг эх нь өргөдөл гаргаагүй хуухдууд энэхуу Гэрээний нэгдүгээр зүйлийн 2, дөрөвдүгээр зүйл болон долдугаар зүйлийн 2-т заасан хугацаа дууссанаас хойш энэхуу Гэрээний заалтын дагуу, зөвхөн Хэлэлцэн Тохирогч хоёр ЭТГЭЭДИЙН аль нэгний харьяатыг хадгална.

Арван нэгдүгээр зүйл

1. Хэлэлцэн Тохирогч хоёр ЭТГЭЭД дипломат шугамаар:

а) Энэхуу Гэрээний долдугаар зүйлийн дагуу харьяатыг нь сонгон авах тухай өргөдөл нь ирэн хуухдуудийн нэрсийн жагсаалтыг жил бүрийн нэг ба гуравдугаар улиралд,

б) Энэхуу Гэрээний нэг ба дөрөвдүгээр зүйлийн дагуу харьяатаа сонгон авах тухай өргөдлөө гаргасан хумуус, эсгүл харьяатыг нь сонгон авахаар эцэг эхээс нь өргөдөл ирэн хуухдуудийн нэрсийн жагсаалтыг энэхуу Гэрээг хучин төгөлдөр болсон өдрөөс хойш 18 сарын дотор нэг нэгэндээ шилжүүлж байна.

2. Харьяатаа сонгон авах тухай гаргасан өргөдөл тус бүр нэг хувийг энэхуу зүйлийн 1-д дурдсан нэрсийн жагсаалтанд хавсаргана.

Арван хоёрдугаар зүйл

Хэлэлцэн Тохирогч хоёр ЭТГЭЭДИЙН эрх бүхий байгууллага нь энэхуу Гэрээг хучин төгөлдөр болмогц Хэлэлцэн Тохирогч нэг ЭТГЭЭДИЙН харьяат байгаа ДЭЛ ЭТГЭЭДИЙН хууль тогтоомжийн дагуу харьяатаас гаргасныг гэрчилсэн баримт бичиг бүхий иргэнийг хэлэлцэн тохирогч нөгөө ЭТГЭЭДИЙН харьяатаар авч болно.

Арван гуравдугаар зүйл

1. Энэхуу Гэрээний дагуу харьяатаа сонгон авах тухай гаргасан өргөдөл аливаа татвар хураамжаас чөлөөлөгдөнө.

2. Хэлэлцэн Тохирогч хоёр ЭТГЭЭДИЙН эрх бүхий байгууллагууд харьяат сонгон авах тухай гаргах өргөдлийн нэгдсэн загварыг боловсруулна.

Арван дөрөвдүгээр зүйл

Энэхуу Гэрээг хэрэгжүүлэх, тайлбарлахтай холбогдон гарч болох асуудлыг дипломат шугамаар шийдвэрлэнэ.

Арван тавдугаар зүйл

1. Энэхуу Гэрээ батлагдах бөгөөд батламж жуух бичгийг Улаанбаатар хотноо солилцсон өдрөөс эхлэн гуч хоногийн дараа хучин төгөлдөр болно.

2. Энэхуу Гэрээг тодорхой хугацаагүйгээр байгуулав. Хэлэлцэн Тохирогч хоёр ЭТГЭЭДЭЭС туунийг цуцлах тухайгаа мэдэгдвэл, ийнхуу мэдэгдсэнээс хойш 6 сарын дараа Гэрээ хучингүй болсонд тооцогдоно.

3. Хэлэлцэн Тохирогч хоёр ЭТГЭЭД энэхуу Гэрээг хэвлэн нийтлэнэ.

Энэхуу Гэрээг 1977 оны 5-р сарын 6-ны өдөр Берлин хотноо герман, монгол хэлээр тус бүр хоёр эх хувь уйлдсэн бөгөөд хоёр эх нь адил хучинтэй байна.

Уунийг нотолж Хэлэлцэн Тохирогч хоёр ЭТГЭЭДИЙН бүрэн эрхт төлөөлөгчид энэхуу Гэрээнд гарын усэг зурж тамга дарав.

БУГД НАЙРАМДАХ
АРДЧИЛСАН ГЕРМАН
УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

Оскар Фишер

БУГД НАЙРАМДАХ
МОНГОЛ АРД УЛСЫГ
ТӨЛӨӨЛЖ

Мангалын Дугэрсүрэн

Bekanntmachung

über die Ratifikation

der Konvention über die Registrierung

von in den Weltraum entsandten Objekten
vom 12. November 1974

durch die Deutsche Demokratische Republik

vom 11. Juli 1977

Der Staatsrat der Deutschen Demokratischen Republik ratifizierte am 12. April 1977 die Konvention über die Registrierung von in den Weltraum entsandten Objekten vom 12. November 1974.

Die Konvention war am 27. August 1975 für die Deutsche Demokratische Republik unterzeichnet worden.

Am 12. Mai 1977 wurde die Ratifikationsurkunde beim Generalsekretär der Vereinten Nationen als dem Depositar der Konvention hinterlegt.

Die Konvention wird nachstehend veröffentlicht.

Gemäß ihrem Artikel VIII Absatz 4 ist die Konvention am 12. Mai 1977 für die Deutsche Demokratische Republik in Kraft getreten.

Berlin, den 11. Juli 1977

Der Sekretär des Staatsrates
der Deutschen Demokratischen Republik

H. Eichler